



## МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2014 оны 12 сарын 19 өдөр

Дугаар 247

Улаанбаатар хот

### Төсвийн шинэчилсэн хуваарь батлах тухай

Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2015 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүний хөгжил сангийн 2015 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон Төсвийн ерөнхийлөн захирагчдаас ирүүлсэн саналыг харгалзан Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.13 дахь заалтыг үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. Сангийн сайдын 2013 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 123 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Монгол Улсын 2014 оны төсвийн орлогын сар, улирлын хуваарь"-ийг 1 дүгээр хавсралтаар, мөн тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Монгол Улсын 2014 оны төсвийн зарлага, санхүүжилтийн сар, улирлын хуваарь"-ийг 2 дугаар хавсралтаар, мөн тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Улсын төсвөөс 2014 оны төсвийн жилд орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг"-ийн хуваарийг 3 дугаар хавсралтаар, мөн тушаалын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Орон нутгийн төсвөөс 2014 оны төсвийн жилд орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд төвлөрүүлэх орлогын сар, улирлын хуваарь"-ийг 4 дүгээр хавсралтаар, мөн тушаалын 5 дугаар хавсралтаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд олгох орлогын шилжүүлгийн сар, улирлын хуваарь"-ийг 5 дугаар хавсралтаар, мөн тушаалын 6 дугаар хавсралтаар батлагдсан "Улсын төсвөөс 2014 оны төсвийн жилд орон нутагт олгох тусгай зориулалтын шилжүүгийн сар, улирлын хуваарь"-ийг 6 дугаар хавсралтаар, мөн тушаалын 7 дугаар хавсралтаар батлагдсан "Улсын төсвийн хөрөнгөөр 2014 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга, байгууламжийн сар, улирлын хуваарь"-ийг 7 дугаар хавсралтаар, мөн тушаалын 8 дугаар хавсралтаар батлагдсан "Эрчим хүч, дулааны алдагдлын 2014 оны татаасын хуваарь"-ийг 8 дугаар хавсралтаар, мөн тушаалын 9 дүгээр хавсралтаар батлагдсан "Монгол Улсын 2014 оны төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн сар, улирлын хуваарь"-ийг 9 дүгээр хавсралтаар, мөн тушаалын 10 дугаар хавсралтаар батлагдсан "Нийгмийн даатгалын сангийн 2014 оны төсвийн сар, улирлын хуваарь"-ийг 10 дугаар хавсралтаар, Сангийн сайдын 2013 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 303 дугаар тушаалын 11 дүгээр хавсралтаар батлагдсан "Хүний хөгжил сангийн 2014 оны төсвийн сар, улирлын хуваарь"-ийг 11 дүгээр хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

Хоёр. Санхүүжилтийг шинэчилсэн хуваарийн дагуу олгохыг Төрийн сангийн газар /Ч.Тавинжил/-т зөвшөөрсүгэй

САЙД



Ж.ЭРДЭНЭБАТ

00 576